



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 26

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дах заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Өндөршил сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9,391,360 /Есөн сая гурван зуун ерэн нэгэн мянга гурван зуун жаран/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хуучин Музейн барилгыг тус сумын Соёлын төвд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг зохих хууль, журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг Өндөршил сумын ЗДТГ-ын дарга /Б.Амгаланжаргал/, бүртгэж авахыг Соёлын төвийн эрхлэгч /Т.Мөнхцэцэг/-д нарт даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

010006